



In partnership with
Canada



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Ашиг сонирхолд тулгуурлан зөрчилдөөнийг удирдах нь

MERIT төслийн зөвлөх Бен Зиеглэр
2022 оны 8-р сарын 29-ний өдөр

Асуулга


POLL

1. Зөрчилдөөний тодорхойлолт, төрөл
2. Зөрчилдөөнийг шийдвэрлэх хүрээ
3. Байр суурь, ашиг сонирхол, асуудал
4. Ашиг сонирхолд тулгуурлан зөрчилдөөнийг шийдвэрлэх – кэйс
5. Харилцаа холбоо


Зөрчилдөөн гэж юу вэ?

Хүмүүсийн зорилго, ашиг сонирхол, зарчим, мэдрэмж
хоорондоо нийцэхгүй илэрхий зөрчилдөх нөхцөл
байдлыг хэлнэ

Зөрчилдөөний төрөл




Үйл явдал



ЗӨРЧИЛДӨӨНИЙ ТӨРӨЛ

ҮЙЛ ЯВДАЛ



Зөрчилдөөнийг шийдвэрлэх хүрээ

Зөрчилдөгч тал шийдвэр гаргах үйл явцад оролцох (involved)	Эв найрамдал
	Хэлэлцээ
	Эвлэрүүлэн зуучлал
	Эвлэрэл
Шийдвэрийг эрх бүхий этгээд гаргах (imposed)	Арбитр
	Хөдөлмөрийн харилцааг зохицуулах эрх бүхий байгууллага/ анхан шатны шүүх
	Анхан шатны шүүх/шүүх
	Үймээн самуун

Хэлэлцээ хийх – Хоёр ба түүнээс дээш тал зөрчилдөөнтэй асуудлаа хэн нэгний туслалцаагүйгээр яриа хэлэлцээний замаар шийдвэрлэх.


Эвлэрүүлэн зуучлах – Талууд хараат бус хөндлөнгийн зуучлагчийн тусламжтайгаар хоорондын асуудлаа шийдвэрлэх. Эцсийн шийдвэрийг талууд гаргана.

Эвлэрүүлэх – Хараат бус хөндлөнгийн этгээд талууд хоорондоо зөрчилдөөнтэй асуудлаа шийдвэрлэхэд нь туслах үүрэг гүйцэтгэх.


Арбитр – Хараат бус хөндлөнгийн этгээд талуудын хооронд үүссэн маргаан, тайлбар, мэдэгдлийг сонсож, хянан шийдвэрлэнэ. Арбитрын үйл ажиллагаа нь шүүхийн хатуу дэг журам, шат дамжлагын дагуу явагдахгүй уян хатан шинж чанартай тул талууд тэгш эрх, харилцан тохиролцооны зарчмыг баримтлана. Арбитрийн шийдвэр эцсийн шийдвэр болох тул давж заалдах боломж хязгаарлагдмал юм.

Шүүхээр шийдвэрлэх – Хараат бус хөндлөнгийн этгээд талуудын дунд үүссэн асуудлыг хянан шийдвэрлэх үйл явц юм. Талууд шүүх үйл ажиллагааны хуулиар тогтоосон дэг журмыг хатуу баримтлах ёстой хэдий ч шүүхийн шийдвэрийг нэг бол хүлээн зөвшөөрөх эсвэл давж заалдах эрхтэй.

Маргааныг зохистойгоор шийдвэрлэх




Мөсөн уул. Мөсөн уулын эх биеийн 90% усны мандал доор байдаг тул та зөвхөн усны мандал дээрх хэсгийг харж, усан доорх хэсгийг харж чадахгүй байх талтай. Таны харж чадахгүй хэсэг аюултай байж болно.



Ашигт сонирхолд тулгуурласан зөрчилдөөн шийдвэрлэх



— Асуудал, байр суурь, ашиг сонирхлыг ялгаж салгах нь



Байр суурь:



Хүрэхийг хүсч буй
үр дүн

Ашиг сонирхол:

Яагаад уг үр дүнд
хүрэхийг хүсч байна вэ?


Асуудал: Ямар учиртай зөрчилдөөн бэ?
(хэн нэгнийг буруутгахгүй байх зарчмыг санах)

Нийтлэг ашиг сонирхолд тулгуурлах



Байр суурь, ашиг сонирхол (жишээ)

Байр суурь



Ашиг сонирхол

Иргэн А

“Нөхцөл байдал
өмнөх шигээ
хэвийн байна”

Ажлын байраа
хэвээр
хадгалах?

Иргэн Б

“Асуудлыг өргөн хүрээнд
харж шийдлийн боломжит
хувилбар боловсруулах
хэрэгтэй”

Карьерийн хувьд
өсөн дэвших?

Нийтлэг ашиг сонирхол?

**Та юу харж байна вэ?
(дахин тодорхойлох урлаг)**



Ашиг сонирхолд суурилан зөрчилдөөнийг шийдвэрлэх– кэйс ажилбар

Дорж, Best Renovations ХХК хооронд үүссэн зөрчилдөөний кэйс:

1. Дорж байгууллагынхаа уулзалтын өрөөг шинэчлэн засуулахаар Best Renovations ХХК-ыг хөлслөн ажиллуулжээ.
2. Дорж засварын ажил дууссаны дараа Best Renovations ХХК-аас 20,000 ам.долларын үнийн дүнтэй нэхэмжлэл хүлээн авав.
3. Дорж нэхэмжлэлийг хүлээн авсны дараа 15.000 ам.долларыг төлбөр болгон шилжүүлж, ажлын гүйцэтгэл хангалтгүйн улмаас үлдэгдэл 5,000 ам.долларыг шилжүүлэх боломжгүй гэдгийг мэдэгдэв. Улмаар Дорж уг компанитай цаашид учир зүйгээ ололцохоос бүр залхаж орхив.
4. Компани үүссэн нөхцөл байдлыг таатай хүлээж аваагүй бөгөөд бүгдийг Доржийн хүссэний дагуу хийснээс гадна Доржийн олон удаагийн хүсэлтийг хүлээн авч, өөрчилж зассан гэж үзэж байв.
5. Компани уг ажлыг хийж гүйцэтгэснээс хойш 6 сар өнгөрсөн хэдий ч үлдэгдэл 5,000 ам.долларын төлбөрийг авч чадаагүй тул залхаж гүйцэв. Компани зарчмын үүднээс Доржоос үлдэгдэл төлбөрийг барагдуулахыг шаардсан боловч тусыг эс олсноос гадна, энэ төвөгтэй харилцагчийг түр орхиж бусад чухал ажлууддаа төвлөрөх шаардлагатай болжээ.

Бүлгийн ажил. Zoom break-out өрөө:

1. Дээрх кэйсийг үндэслэн дараах хүснэгтийг бөглөх
2. Үндсэн хэсэг рүү буцаж, бүлгийн ажлаа танилцуулах (бүлгийг төлөөлөн танилцуулах хүнийг сонгох)



	Дорж	Best Renovations ХХК
Асуудал (Ямар зөрчилдөөн үүссэн бэ? Хэн нэгнийг буруутгахгүй, төвийг сахих)		
Байр суурь (Ямар үр дүнд хүрэхийг хүсч байна вэ?)		
Ашиг сонирхол (Яагаад энэ үр дүнг хүсч байна вэ?)		
Нийтлэг ашиг сонирхол		
Зөрчилдөөнийг шийдэх боломжит хувилбар		15

Идэвхтэй бус Идэвхтэй

Бүтээлч, үр дүнтэй

Асуудлыг нөгөө талын
өнцгөөс харах
Шийдэл боловсруулах
Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх

Эхний алхмыг хийх

Эргэцүүлэн бодох
Хариу үйлдлийг хойшлуулах
Дасан зохицох

Бүтээлч бус

Ямар ч арга, үнэ цэнээр
хамаагүй ялж дийлэх
Уур уцаараа ил гаргах
Бусдыг доромжлох
Хариугаа авах

Зайлсхийх
Бууж өгөх
Сэтгэл хөдлөлөө нуух
Өөрийгөө шүүжлэх

Бүтээлч, үр дүнтэй хариу – эхний алхам хийх

Эхний алхам хийх:

- Зөрчилдөөнөөс үүдэлтэй сэтгэл санааны хохирлыг арилгахыг эрмэлзэх
- Харилцааг дахин эхлүүлэх эхний алхмыг хийх

Асуулт:

1. Яагаад ихэнх хүмүүст эхний алхам хийх зан төлөвийг төлөвшүүлэхэд хүндрэлтэй байдаг вэ?
2. Уучлалт гуйх нь ямар нөлөө үзүүлдэг вэ?
3. Яагаад ихэнх хүмүүс зөрчилдөөнийг амжилттай шийдэх боломж бий гэдэгт итгэлгүй байдаг вэ?



Харилцаа

‘Харилцаа’ гэдэг үг нь латин хэлний
‘Communis’ буюу **‘Нийтлэг’**
болгох гэсэн утгатай үгнээс
гаралтай.



Ойлголцолд хүрэх

Хувийн

Бусдын

Санаа
зорилго

Үр нөлөө

Үйлдэл
(Зан төлөв)

Стратегитай харилцах нь (нээлттэй ярилцаж, далд ашиг сонирхлыг илрүүлэх)

1. Нөгөө талын ашиг сонирхол, асуудлыг шийдэхэд баримтлах шалгуурыг мэдэх зорилгоор **нээлттэй асуулт асуух.**
2. Ашиг сонирхол, шалгуурын талаар сайтар тодруулах, шаардлагатай бол **дэлгэрүүлж асуух.**
3. Нөгөө талын **ашиг сонирхлыг** мэдсэн тохиолдолд **өөрийн үгээр лавшруулан асуух** замаар баталгаажуулах.
4. Ижил сэдвийн хүрээнд өөрийн сонирхлоо **илэрхийлэх.**
5. Нийтлэг болон ялгаатай ашиг сонирхлыг **нэгтгэн дүгнэх:** шинэ мэдлэг, ойлголт, шалгуур үзүүлэлт.

Дүгнэлт

Таны хувьд амжилтын жор юу вэ?

Бүлгийн ажлын асуулт (Zoom breakout өрөө):

1. Өнөөдрийн сургалтын агуулга, хэлэлцсэн асуудлыг эргэцүүлэн бодох.
2. Өнөөдрийн сэдвийн хүрээнд өөрийн "амжилтын жор"-ыг тодорхойлох. Тухайлбал цаашид Та болон танай байгууллага "ашиг сонирхолд тулгуурлан зөрчилдөөнийг шийдвэрлэх" чиглэлээр албан хаагчдын мэдлэг, ур чадварыг хэрхэн бэхжүүлэх боломжтой вэ?

Бүлгийн ажлын явц:

1. Өрөөнд хуваарилагдахаас өмнө асуултыг тэмдэглэж авах, зургийг авах
2. Бүлгийн гишүүдийн дэвшүүлсэн амжилтын жороос 3 зүйлийг тэмдэглэх
3. 20 минутын дараа үндсэн хэсэг рүү буцах
4. Бусад оролцогчдод хариултаа танилцуулах (бүлгийг төлөөлөн танилцуулах хүнийг сонгох)



Монгол Улс:
Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс
баялгийн менежментийг сайжруулах (MERIT)

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Худалдааны гудамж, Нэйшнл Таймс Ньюс Тауэр, 3-р давхар

Утас: 7610-5000